


1. Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цагаан агуйн дурсгал хэдий үед хамаарах вэ? (1 оноо)
A. 1 сая жилийн үед
B. 800 мянган жилийн үед
C. 40 мянган жилийн үед
D. 500 мянган жилийн үед
E. 80 мянган жилийн үед
2. Жужан (Нирун) улс хэдий үед оршин тогтнож байсан бэ? (1 оноо)
A. 535-655 он B. 535-555 он C. 745-840 он D. 330-555 он E. 555-745 он
3. Монгол нутаг дахь төмрийн түрүү үеийн соёлын томоохон дурсгалт газар аль вэ? (1 оноо)
A. Дорнод аймгийн Тамсагбулаг
B. Дундговь аймгийн Ярх уул
C. Увс аймгийн Чандмань уул
D. Хэнтий аймгийн Рашаан хад
E. Өмнөговь аймгийн Оцон-Мааньт
4. “Газар бол улсын үндэс” хэмээх төр ёсны уламжлалын зарчмыг хэн үндсэлсэн бэ? (1оноо)
A. Түмэн шаньюй B. Чингис хаан C. Өгөдэй хаан
D. Модунь шаньюй E. Хубилай
5. Сяньби нарын уугуул нутаг аль нь вэ? (1оноо)
A. Хянганы нурууны төв, зүүн тал
B. Монгол орны баруун өмнөд хэсэг
C. Монгол орны баруун хойд хэсэг
D. Хянганы нурууны баруун тал
E. Аль нь ч биш
6. Түрэгийн үеийн “Хөшөө дурсгал”-ын танин мэдэхүйн болон судалгааны ач холбогдол юу вэ?(1оноо)
A. Түрэгийн түүхийн эх сурвалж
B. Дүрслэх урлаг, соёлын дурсгал
C. Түрэгийн үеийн монгол аймгийн зарим асуудлыг тодруулах эх сурвалж
D. Түрэг бичгийн дурсгал
E. Бүгд зөв
7. Сэлэнгэ мөрний хөвөөн дээр орших Орду-балык хот аль улсын нийслэл вэ? (1оноо)
A. Жужан (402-555 он) B. Түрэг (555-745 он) C. Уйгур (745-840 он)
D. Киргиз (840-870 он) E. Хятан (907-1123 он)
8. XI-XII зууны үеийн Татарын ханлиг хаагуур нутаглаж байсан бэ? (1 оноо)
A. Гурван голын сав
B. Онон мөрний хөндий
C. Онон мөрний хөндий, Сэлэнгийн эхээр
D. Хөлөн, Буйр нуур орчмоор
E. Орхон голоос Эрчис мөрөн, Зайсан нуур хүртлэх газар
9. Монголын нууц товчоонд өгүүлснээр “Хабул хааны долоон хөвгүүний дундах Хотулад очиж хэл. Хамгийн хаан улсын эзэн байтал охиноо өөрөө үдэж хүргэхийг надаар цээрлэл болгогтун. Би татар аймагт баригдав. Миний өшөөг авахыг оролдогтун” гэж хэн гэрээсэлсэн бэ? (1 оноо)
A. Хабул хаан B. Амбагай C. Хотула D. Хадаан тайш E. Тэмүжин

10. Тэмүжин, Хамаг Монголын ханлигийг дахин сэргээж, хэдэн онд, хаана “Чингис” цолтойгоор хаанд өргөмжлөгдсөн бэ? (1 оноо)
 А.1189 он, Алтайн нуруунд
 В.1162 он,Ононы Дэлүүн болдлогт
 С.1202 он, Бүрги эрэгт
 D.1189 он,Хар Зүрхний Хөх нуурт
 E.1206 он, Онон мөрний эхэнд
11. “Есөн татар” гэсэн нэр ямар сурвалжид анх тэмдэглэгдсэн байдаг вэ? (1 оноо)
 А. Монголын нууц товчоо
 В. Моюунчур хааны гэрэлт хөшөө
 С. Культегиний хөшөө
 D. Билгэ хааны хөшөө
 E. Аль нь ч биш
12. Домогт Алангоо эх таван хүүдээ сургаж өгүүлсэн сургаалын гол агуулга юу вэ? (1 оноо)
 А. Эв эе нэгтгэвэл багласан сум мэт бэх болж, хэнд ч хялбар дийлдэгдэхгүй болохыг сургасан
 В. Түрэг, Монгол аймгуудын хорондын тэмцлийг өгүүлсэн
 С. Улс төрийн бутралыг даван туулах
 D. Шашны тугийн дор хаант төрийг сэргээх
 E. Манжийн түрэмгийллийн эсрэг нийт монголчуудын хүчийг нэгтгэх
13. Хамаг Монголын ханлигийн анхны хаан хэн бэ? (1оноо)
 А. Хабул хаан
 В. Амбагай хаан
 С. Хотула хаан
 D. Бартан баатар
 E. Есүхэй баатар
14. Монголын түүхэнд холбогдох монгол бичгийн анхны дурсгал аль нь вэ? (1 оноо)
 А. Монголын нууц товчоо
 В. Чингисийн чулууны бичиг
 С. Мөнх хааны гэрэлт хөшөөний бичээс
 D. Юан улсын түүх
 E. Аль нь ч биш
15. Тэмүжин “хагацсан улсаа хамтатгах, бутарсан улсаа цуглуулах”-даа хэнийг түшиглэсэн бэ? (1оноо)
 А. Хэрэйдийн Тоорил ван
 В. Найманы Таян хан
 С. Гурван Мэргэд
 D .Татар аймаг
 E. Алтан улс
16. Их Монгол улсын түмний ноёдын нэрийг зөв тохируулна уу. (3 оноо)
 1. Төвийн түмэн а.Боорчи
 2. Зүүн түмэн б. Мухулай
 3. Баруун түмэн в. Наян
 А.1в,2а, 3б В.1а,2б,3в С. 1а,2в,3б D. 1б,2в,3а E.1в,2б,3а
17. Чингис хааны түүхэн гавьяаг өгүүлэхэд илүүц зүйл аль нь вэ? (2 оноо)
 А. Үндэс угсаагаа дээдлэн мөнхжүүлэгч, үндэсний баатар
 В. Монголын нэгдсэн улсыг байгуулсан аугаа их улс төрч
 С. Аугаа их жанжин
 D. Өрнө, дорны соёлын хэлхээ холбоог бэхжүүлэн хөгжүүлэгч
 E. Илүүц зүйл үгүй
18. Аль нь эцэг, хүү, ач, гуч вэ? (2 оноо)
 А. Чингис, Тулуй, Гүюг, Хубилай
 В. Чингис, Тулуй, Гүюг, Өгэдэй
 С. Есүхэй, Чингис, Өгэдэй, Гүюг
 D.Тулуй, Мөнх, Хубилай, Бат

- Е. Зүчи, Бат, Мөнх, Хубилай
19. Гүүг хааны дотоод, гадаад бодлогод үл хамаарах зүйл аль нь вэ? (2 оноо)
 А. Хүн амын тооллого явуулсан
 В. Төрийн эрх мэдэл булаацалдах хэрэгт идэвхтэй оролцогчдыг цээрлүүлэн шийтгэсэн
 С. Туракина хатаны үед гаргасан зарлиг, гэрэгээг хүчингүй болгосон
 D. Их цэрэг авч өрнө зүг Эмиль нутаг руу мордсон
 E. Үл хамаарах зүйл байхгүй
20. Мөнх хаанд зориулан босгосон гэрэлт хөшөөг хаанаас олсон бэ? (1оноо)
 А. Хөвсгөл аймгийн Арбулаг сум
 В. Булган аймгийн Сайхан сум
 С. Бээжингийн ойролцоо Ханбалиг
 D. Төв аймгийн Жаргалант сум
 E. Сэлэнгэ аймаг
21. Ил хаант улсын түүхэнд холбогдох өгөгдлийг нэрлэнэ үү. (2 оноо)
 А.Хүлэгүгийн улс
 В.Ираны нутагт байсан, нийслэл Тебриз хот
 С.Сударын чуулган
 D. Өлзийт хаан
 E.Бүх хариулт зөв
22. Доорх зурагт юуны тухай өгүүлж байна вэ? (1 оноо)
 А. Соёмбо үсгийн дурсгал
 В. Дөрвөлжин үсгийн пайз
 С. Гүүг хааны таманы дардас
 D. Ил хаадын захидал
 E. Чингисийн чулууны бичиг
- 
23. “Амь нь бат, үйлс нь мөнх даяар олны эзэн болтугай” хэмээн, “Даян хаан” цолыг хэнд олгосон бэ? (2оноо)
 А.Тогоон В. Алтан С. Батмөнх D. Занабазар E. Галдан
24. Даян хааны үеийг монголын түүхийн сурвалж бичгүүдэд хэрхэн томьёолсон байдаг вэ? (2оноо)
 А. Улсын нэгдмэл байдал алдагдсан В. Салан тусгаарласан үе
 С.“Гар газар, хөл хөсөр” байсан үе D.“Үлэмж жаргалангаар хүн амьтныг хангаж байсан” үе
 E. Дээрх хариулт бүгд зөв
25. Халхын ноёд Манжид дагаар орох шийдвэрийг хэзээ, хаана, ямар чуулганаар гаргасан бэ? (1 оноо)
 А.1640 он, Тарвагатайн улаан бураа В.1686 он, Хүрэн бэлчир
 С. 1688 он, Ар Элстэй D.1691 он, Долоон нуур
 E. 1685 он, Ил Тарвагатай
26. Монголын түүхэнд XIV зууны сүүлчээс XVII зууныг улс төрийн бутралын үе гэж нэрлэдэг. Улс төрийн бутрал болсон гол шалтгаан юу вэ? (2 оноо)
 А. Мин улсын хагалган бутаргах бодлого, үйл ажиллагаа
 В. Хаад, ноёдын дарлал хэрээс хэтэрч, дааж давшгүй алба татвар оногдуулах болсноор ард олны бослого тэмцэл байнга гарч улс орныг туйлдүүлсэн
 С. Эдийн засгийн хувьд бэхжин, бие даах чадвартай болсон язгууртан ноёдын улс төрийн талаар тусгаарлах гэсэн эрмэлзэл, тэмцлээс үүдэлтэй
 D. Олон жил үргэлжилсэн ган, зуд нь улс орны эдийн засгийг доройтуулсан

- Е. Дээрх бүгд буруу
27. Өвөр Монгол Манжид эзлэгдсэн оныг олно уу. (1 оноо)
 А.1688 он В.1691 он С.1634 он D.1636 он E.1631 он
28. Манжийн эрхшээлийн үеийн монгол ноёд, язгууртнуудын албат ардыг гэж нэрлэж байв. (2оноо)
 А.Сум ард В.Хамжлага ард С.Шавь ард D.Хишигтэн E.Хэвтүүл
29. Баруун Монголд, манжийг эсэргүүцсэн 1755-1758 оны тэмцэлд ямар хэлбэр зонхилж байсан бэ? (1оноо)
 А.Зэвсэгт бослого В.Дугуйлангийн хөдөлгөөн С. Заргын тэмцэл
 D. Өртөө харуулыг хаяж босох E. Аль нь ч биш
30. Ойрадын Зая Бандид, “Тод үсэг” зохиосон 1648 он хэддүгээр зууны, хэддүгээр хагас вэ? (2оноо)
 А. XV зууны II хагас В.XVII зууны I хагас С.XVII зууны II хагас
 D. XVI зууны I хагас E.XVI зууны II хагас
31. Манжийн үеийн Засагт хан аймаг нь одоогийн аль аймгуудын нутаг дэвсгэртэй дүйж байна вэ? (2 оноо)
 А. Завхан, Говь-Алтай зэрэг аймаг В.Хэнтий, Сүхбаатар зэрэг аймаг
 С.Өвөрхангай, Төв зэрэг аймаг D.Архангай, Булган зэрэг аймаг
 E.Аль нь ч биш
32. Манжийн хааны мал сүргийг Ар Монголд хаана хариулдаг байсан бэ? (1оноо)
 А.Түшээт хан аймагт В.Дарьгангад С.Засагт хан аймагт
 D.Улиастайд E.Ховдын хязгаарт
33. Манжийн эрхшээлийн үед ганц биеээр очиж хаадаг хугацаатай албыг гэж нэрлэж байв. (2оноо)
 А.Суман харуул В.Гэр харуул С.Алтны харуул
 D.Дотуур харуул E.Цагдаа харуул
34. 1911 оны зун Халхын эрх баригч дээд ноёд, лам нарын нууц зөвлөлгөөн хаана болсон бэ? (1оноо)
 А.Улиастай В.Ховд С.Их хүрээ D.Хиагт E.Аль нь ч биш
35. 1911.12.29-нд Монголчууд төрийн тусгаар тогтнолоо сэргээн Богдыг хаан ширээнд залж таван яам байгуулжээ. Дотоод яамны сайдаар хэнийг томилсон бэ? (1оноо)
 А. Да лам Цэрэнчимэд В. Намсрай ван С. Бэйс Гомбосүрэн
 D. Чин ван Ханддорж E. Чагдаржав
36. Доорх зураг түүхийн ямар мэдээлэл агуулагдаж байна вэ? (2 оноо)
 А. Эрт цагт бяр чадалтай хүмүүс байсан гэдгийг харуулсан
 В. Домгийн баатар хүнийг илэрхийлсэн
 С. Монголчууд гадаад, дотоодын олон давхар дарлалд нухлагдаж байсан
 D. Гэрээ үүрч яваа бөх хүн
 E. Аль нь ч биш



37. 1911.12.29-нд Монгол улс тусгаар тогтнолоо сэргээн тунхаглаж, улсын нэр,оны цолыг хэрхэн өргөмжилсөн бэ? (2оноо)
- A. Оны цолыг Олноо өргөгдсөн
 - B. Улсын нэрийг Тусгаар Монгол улс, оны цолыг Олноо өргөгдсөн
 - C. Улсын нэрийг Монгол улс, оны цолыг Олноо өргөгдсөн
 - D. Улсын нэрийг Хаант улс, оны цолыг Олноо өргөгдсөн
 - E. Аль нь ч биш
38. 1912 оны Монгол, Оросын “Гэрээ бичиг” –ийн **гол** ач холбогдол юу вэ? (2 оноо)
- A. Монгол улсыг эдийн засгийн талаар бэхжүүлсэн
 - B. Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн
 - C. Оросын худалдаачдаар дамжин бараа таваарын гачигдлаас гаргасан
 - D. Орос улстай эрх тэгш харилцаа тогтоосон
 - E. Ар Монголыг өөртөө хүчээр нэгтгэх гэсэн Хятадын бодлогод цохилт болсон
39. Хаант Орос улсын туслалцаатайгаар монгол цэргийн сургууль хаана байгуулагдсаныг нэрлэнэ үү.
- A.1912 онд Хужирбуланд
 - B.1913 онд Амгалан баатар хотод
 - C.1914 онд Улиастайд
 - D.1912 онд Хиагтад
 - E.Аль нь ч биш
40. 1919 онд Гадаад Монголын автономит эрхийг цэргийн хүч далайлган устгасан Хятадын цэргийн генералыг нэрлэнэ үү. (2оноо)
- A.Чен-И
 - B.Саньдо амбан
 - C.Юань-Шикай
 - D.Мао Цзэдун
 - E.Сюй Шу Жан
41. Монгол, Зөвлөлт хоёр улсын 1921.11.05-ны өдөр байгуулсан гэрээний **гол** агуулга юу вэ? (2 оноо)
- A. 1912 оны найрамдлын гэрээ бичгийг үргэлжлүүлэн мөрдөх тухай
 - B. 1931 он хүртэл 10 жилийн хамтын ажиллагааны зарчим
 - C. Хятадын эсрэг эдийн засгийн талаар хамтран ажиллах тухай
 - D. Хоёр улсын Засгийн газар харилцан бие, биеэ хүлээн зөвшөөрч, найрамдалт харилцаа тогтоох тухай
 - E. Дээрх хариулт бүгд буруу
42. БНМАУ-ын анхдугаар Үндсэн хуулиар ямар хүмүүсийн улс төрийн эрхийг хассан бэ? (2 оноо)
- A. Бусдыг хөлсөөр ажиллуулагсад
 - B.Урьдын хаад ноёд, хутагт хувилгаад
 - C. Хүрээ хийдэд байнга суудаг лам нар
 - D. Дээрх хариулт бүгд зөв
 - E. В ба С хариулт зөв
43. Монгол улсын анхдугаар “Үндсэн хууль” хэдэн онд батлагдсан бэ? (1 оноо)
- A.1924.11.26
 - B.1924.05.10
 - C.1926.12.10
 - D.1924.02.11
 - E.1921.01.13
44. Ардын засгийн газрын анхны Ерөнхий сайд, Гадаад яамны тэргүүн сайд хэн байсан бэ? (1оноо)
- A. Пунцагдорж
 - B. Д.Сүхбаатар
 - C. Д.Бодоо
 - D. Н. Магсаржав
 - E. С.Данзан
45. Шинжлэх ухааны байгуулгын үндэс “Судар бичгийн хүрээлэн” –ийн гол үүрэг юу вэ? (1оноо)
- A. Хууль гаргах
 - B.Түүхэн дурсгалыг цуглуулах, хадгалах, судлах
 - C. Эдийн засгийн бодлого боловсруулах
 - D. А ба В хариулт зөв
 - E. Аль нь ч биш

46. МАН-ын гуравдугаар их хуралд “МАН-ын эцсийн зорилго нь эв хамтын ёс бөгөөд нам капитал хөрөнгөтний ёсыг алгасан энэ зорилгод хүрэх ёстой” гэж улс орны хөгжлийн ирээдүйн зорилтыг тодорхойлсон сэдвийг хэн оруулж хэлэлцүүлсэн бэ? (2оноо)
А. С.Данзан В. Э.Д.Ринчино С. Б.Цэрэндорж D. А.Амар E. Д.Бодоо
47. Монголын эрх баригчдын дотроос Коминтерн, ЗХУ-ын удирдагчдын зөвлөлгөөнд хэт итгэн нугалаа гажуудал гаргаж байсан хүмүүсийг нэрлэнэ үү. (2оноо)
А.Ө.Бадрах, П.Гэндэн, З.Шижээ В. А.Амар, Ж.Цэвээн, Ц.Дамбадорж, Н.Жадамба
С.Ө.Бадрах, Ц.Жигжиджав, А.Амар D.А ба В хариулт зөв E.В ба С хариулт зөв
48. БНМАУ нь Нэгдсэн Үндэсний байгууллагад гишүүнээр элсжээ. (2оноо)
А.1946 он В.1945 он С.1961 он D.1966 он E.Аль нь ч биш
49. Улаанбаатар-Наушкийн төмөр зам ашиглалтанд орсон нь ямар ач холбогдолтой вэ? (2оноо)
А. Орчин цагийн төмөр замын тээврийн салбарын үндэс тавигдсан
В. Морин өртөөг бий болгосон
С. Төмөр замын салбарын инженер техникийн ажилчид бий болсон
D. А ба С хариулт зөв
E. Дээрх хариулт бүгд буруу
50. “Монголын ардчилсан холбоо” хэзээ, хаана байгуулагдсан бэ? (1оноо)
А.1989.12.10. Улаанбаатар В. 1989.12.12. Ховд С.1990.12.10 Хөвсгөл
D. 1990.12.12. Дархан E. 1989.12.20 Улаанбаатар
51. 1990-1992 онд ерөнхий сайдаар ажиллаж байсан улс төрийн зүтгэлтэн хэн бэ? (1 оноо)
А. Н.Багабанди В. П.Очирбат С. Д.Бямбасүрэн D. С.Зориг E. Ц.Элбэгдорж
52. Монгол улсын шинэ “Үндсэн хууль”-нд зааснаар гүйцэтгэх дээд байгууллага аль нь вэ? (1оноо)
А. УИХ В. Ерөнхийлөгч С. Засгийн газар D. Ерөнхий сайд E. Аль нь ч биш
53. Дор дурьдсан өгөгдлөөс “Азарганы ноцолдоон” бүтээлийн зураачийг нэрлэнэ үү. (1оноо)
А. Л.Ванган В. Э.Оюун С. Д.Нацагдорж D. Ч.Ойдов E. О.Цэвэгжав
54. XX зууны Монголын үнэтэй хувь нэмэр оруулсан төлөөлөгчид бол Б.Сумхүү, Ж.Бунтар, О.Уртнасан нар юм. (2оноо)
А. Кино урлагт В. Утга зохиолд С.Бүжгийн урлагт D. Хөгжмийн урлагт E. Дүрслэх урлагт
55. Манжийн үеэс одоог хүртэл уламжилж ирсэн засаг захиргааны нэгж аль нь вэ? (1 оноо)
А. Нийслэл В. Дүүрэг С. Сум D. Хороо E. Хошуу
56. 1990 онд батлагдсан “Улс төрийн намуудын тухай хууль”-ийн гол агуулга юу вэ? (1 оноо)
А. МАХН-ын манлайлах үүргийг хуульчилсан
В. Олон намын систем тогтох эрх зүйн үндсийг бүрдүүлсэн
С. Улс төрийн намыг шинээр байгуулахыг хориглосон
D. А ба В хариулт зөв
E. Аль нь ч биш

Хоёрдугаар хэсэг

2.1 Дараах өгөгдлүүдийг зөв тохируулна уу. (1,2,3,4,5 тус бүрт харгалзах утга a,b,c,d,e -ээс сонгоно уу.)

- | | | |
|-----------------------------------|------------------------------|----------|
| 1. Дорнодын Тамсагбулгийн дурсгал | a. Хуучин чулуун зэвсгийн үе | (5 оноо) |
| 2. Культегиний гэрэлт хөшөө | b. Шинэ чулуун зэвсгийн үе | |
| 3. Ховдын Хойд Цэнхэрийн агуй | c. Хүннүгийн үе | |
| 4. Ноён уулын соёл | d. Түрэгийн үе | |
| 5. Дөрвөлжин булш | e. Хүрэл, Төмрийн үе | |

2.2 Дараах өгөгдлүүдийг зөв тохируулна уу. (1,2,3,4,5 тус бүрт харгалзах утга a,b,c,d,e -ээс сонгоно уу.)

- | | | |
|------------------|--|----------|
| 1. Марко Поло | a. Судрын чуулган | (5 оноо) |
| 2. П.Карпини | b. Дорно этгээдэд зорчсон нь | |
| 3. Г.Рубрук | c. Монголчуудын түүх | |
| 4. Рашид ади Дин | d. Орчлонгийн элдэв сонин | |
| 5. Жувейн | e. Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх | |

2.3 Дараах өгөгдлүүдийг зөв тохируулна уу. (1,2,3,4,5 тус бүрт харгалзах утга a,b,c,d,e -ээс сонгоно уу.)

- | | | |
|---------------------------------------|------------------|----------|
| 1. Юань гүрэн | a. Бат | (5 оноо) |
| 2. Дундад Ази дахь Монголын хаант улс | b. Хүлэгү | |
| 3. Иран дахь Монголын хаант улс | c. Тогоонтөмөр | |
| 4. Алтан ордны улс | d. Доголон Төмөр | |
| 5. Их Монгол улс | e. Өгөдэй | |

2.4 Дараах өгөгдлүүдийг зөв тохируулна уу. (1,2,3,4,5 тус бүрт харгалзах утга a,b,c,d,e -ээс сонгоно уу.)

- | | | |
|--|------------|----------|
| 1. Заг Байдрагийн хүрэн бэлчир | a. 1640 он | (5 оноо) |
| 2. Өвөр Монголын Долоннуур | b. 1686 он | |
| 3. Ил Тарвагатайн Улаан бураа | c. 1688 он | |
| 4. Өвөр Монголын нутаг Ар элстэй | d. 1691 он | |
| 5. Ардын Их хурлын чуулган Улаанбаатар | e. 1978 он | |